



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Геодези, зураг зүйн орон тооны бус
мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 160 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 160 дугаар тушаалаар батлагдсан "Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ын 4.5 дахь заалтын дагуу мэргэжлийн зөвлөлийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргыг сонгож газрын даргын тушаалаар батлуулахыг Геодези, зураг зүйн хэлтсийн дарга Д.Мөнхцэцэгт даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын "Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" 2019 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/71 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/287 дугаар, 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/118 дугаар, 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/129 дүгээр, 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/147, А/148, А/149 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1578019308

Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газрын даргын 2022 оны 130 дугаар
тушаалын хавсралт



Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн

№	Овог, нэр, утас	Байгууллага, албан тушаал	Мэргэжил, цол, зэрэг
1.	Д.Мөнхцэцэг 99154382	ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-ийн дарга	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
2.	Б.Болормаа 99053716	Баясах сурвей ХХК-ийн инженер	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
3.	Ц.Дашзэвгэ 99083346	МГФЗЗХ-ны УЗ-ийн гишүүн	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
4.	А.Сумъяа 99062309	Чандмань сурвей ХХК-ийн гүйцэтгэх захирал	Геодезийн инженер, МУ-ын мэргэшсэн инженер
5.	Я.Сандагдорж 91112323	Эм Пи Эм ХХК-ийн захирал	Зураг зүйч инженер, МУ-ын зөвлөх инженер
6.	О.Хосбаяр 99088235	МГФЗЗХ-ны тэргүүн	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
7.	Т.Балжинням 99290324	ХААИС-ийн Агро-экологийн сургуулийн профессор зөвлөх	МУ-ын зөвлөх инженер, Доктор.проф
8.	П.Эрдэнэчимэг 88056133	ШУТИС, ГУУС-ийн Геодезийн салбарын дэд профессор	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер Доктор
9.	Г.Нарантуяа 99137789	ҮТИС-ийн багш, эрх зүйч	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
10.	П.Алтанцэцэг 99073484	АХБ-ны төслийн зөвлөх	Геодезийн инженер, МУ-ын мэргэшсэн инженер
11.	Ю.Чүлтэм 99164934	"Геомэп" ХХК-ийн захирал	Геодезийн инженер, МУ-ын зөвлөх инженер
12.	Б.Амарзаяа 99259285	ГЗБГЗЗГ-ын ГЗЗХ-ийн ахлах мэргэжилтэн	Геодезийн инженер, МУ-ын мэргэшсэн инженер



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/᠑8

Улаанбаатар хот

Орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн
дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргыг
томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Барилга, хот байгуулалтын Сайдын 2016 оны 160 дугаар тушаалаар баталсан "Архитектор, инженерийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ын 3.2, 4.5, 5.9 дэх хэсэг, Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 2022/01 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн даргаар О.Хосбаяр, орлогч даргаар Д.Мөнхцэцэг, нарийн бичгийн даргаар Геодези, зураг зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Амарзаяаг тус тус томилсугай.

2. Геодези, зураг зүйн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2022 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу зөвлөлийн хурлыг зохион байгуулахыг Геодези, зураг зүйн хэлтэс /Д.Мөнхцэцэг/-т, зөвлөлийн дарга /О.Хосбаяр/-д тус тус даалгасугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1522010322